



Зохиогч: Г.Мягмарсамбуу. "Төр, цэргийн нэрт зүтгэлтэн, домогт жанжин Ардын Хатан баатар С.Магсаржав" /1878-1927 он/ УБ.,2011. хэмээх нэгэн сэдэвт зохиол. Энэхүү бүтээл нь Хянан зовлогчийн үг, Омнох үг, үндсэн 4 бүлэг, 11 зүйл, хавсралт, эш татсан сурвалж, судалгааны зохиолоос бүрдэнэ. Нийт хэмжээ 28,2 хэвлэлийн хуудас буюу "Б5" хэмжээтэй 282 тал.Хянан зовлогч доктор /Ph.D/, профессор С.Баасанхүү.

Энэ бүтээлийн шинэлэг тал, гол онцлогийг тодорхойлбол,

- 1912-1922 он хүртэлх хугацаанд Хатанбаатар С.Магсаржавын удирдлагаар явуулсан байлдааныг цаг хугацаа, үе шатаар нь нэлээд тодорхой гаргаж /Тал 28-108/, тэдгээрийг Монгол Улсын газрын зурагт оруулан хавсаргав. Энэ нь XX зууны монгол цэргийн дайн байлдааны талаар уншигчдад шинэ мэдлэг, ойлголт огох тодийгвй энэ чиглэлээр судалгаа явуулах хүмүүст сонирхолтой гарын авлага болох учиртай.

- Эдгээр байлдаанд Хатанбаатар С.Магсаржавын хэрэглэж байсан байлдах арга ухааныг тодруулахыг оролдов /Тал 118-127/. Ялангуяа, 1912 оны Ховд хотыг чолоолох байлдаан, 1921 онд баруун хязгаарыг цагаантнаас чолоолох байлдаанд хэрэглэж байсан арга тактикийг нэлээд тодруулж, Ховдыг чолоолох байлдааны тактикийн зургийг оруулсан юм.

- Хатанбаатар С.Магсаржавын цэргээ удирдаж байсан арга ухааны онцлогийг анх удаа судлан тодруулж /Тал 109-117/, тэр нь ялалт амжилтынх нь нэг үндэс болж байсан гэсэн дүгнэлт хийсэн юм.

- Энэ бүтээлд ЦЯЯ-ны сайд С.Магсаржавын үйл ажиллагаагаар дамжуулан 1922-1927

оны хооронд АЖЦ-ийг байнгын цэрэг болгон шинэчлэн хөгжүүлсэн түүхийг тодорхой гаргав. Ялангуяа, орон нутгийн цэрэг, цэргийн сургалт, бэлтгэл, аймгуудад Цэргийн хэлтэс байгуулсан, Цэргийн сургуулийн сургалт бэхжилт, ЦЯЯ-наас хил хязгаарыг сахин хамгаалах талаар авсан арга хэжээ, Монгол, Оросын цэргийн харилцаа, хоёр орны хооронд байгуулсан гэрээ хэлэлцээр, Цэргийн яамны жанжин тугийн тахилгын талаар архивын шинэ баримтанд үндэслэн нухацтай авч үзсэнийг онцлон тэмдэглэж байна.

- Уг бүтээлд Ардын тороос улс орны батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх, АЖЦ-ийг оорчлон шинэчлэх талаар баримталсан бодлого, гаргасан шийдвэрийг нэлээд тодорхой тусгав. Энэ зорилгоор удаа дараагийн Улсын Их, Бага хуралд ЦЯЯ, БЦЗ-оос оруулж хэлэлцүүлсэн илтгэл, тэдгээр хурлаас гаргасан шийдвэрийг үнэлж дүгнэсэн юм. Энэ нь торийн батлан хамгаалах бодлогын уламжлалыг тодруулахад зохих түлхэц болох учиртай.

Бүхэлд нь авч үзвэл энэхүү бүтээлд 1911-1920-иод оны сүүлч хүртэлх хугацаанд монголчуудаас эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолын толоо явуулсан дайн байлдаан, байлдах арга ухаан, Зэвсэгт хүчний үүсэл, хөгжлийн асуудлыг архивын баримт мэдээнд тулгуурлан нухацтай авч үзэхийг оролдсон билээ. Энэ бүтээл цэргийн шинжлэх ухааны онол, урлагийн чиглэлийн 2011 оны шилдэг бүтээлээр шалгарсан байна. Батлан хамгаалахын сайдын 2011.12.02-ны одрийн "Нэрэмжит бүтээлийг шагнах тухай" тушаалд энэхүү бүтээлийг ЗХ-ний офицер, ахлагч, БХИС-ийн сонсогч, хугацаат цэргийн албан хаагчдын заавал судлах ном бүтээлийн жагсаалтад оруулж, олны хүртээл болгохыг холбогдох албан тушаалтанд үүрэг болгожээ.